

КАЗАХСТАН УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Өнөөдөр Казахстан нь тогтвортой хөгжиж буй эдийн засагтай, нийгэм улс төрийн тогтвортой байдал бүхий улс юм. Гадаадын шинжээчид Казахстаныг төв Азийн “Эдийн засгийн зүтгүүр” хэмээн нэрлэсэн билээ. Өнөөдөр Казахстанд Төв Азийн бусад орнуудаас эдийн засгийн давуу талууд бий. Сүүлийн жилүүдэд тус улс нь эдийн засгийн өсөлтийн өндөр үзүүлэлт үзүүлж байгаа билээ. 2006 онд Казахстаны ДНБ 9 хувиар өсөж, үндсэн хөрөнгө оруулалт 25 хувь, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ 7 хувиар тус тус өссөн байна. Өнөөгийн байдалд нэг хүн амд ноогдох ДНБ бараг 7 мянган ам.долларт хүрээд байна.

Шинжлэх ухааныг улсаас дэмжих дэмжлэгийг нэмэгдүүлж, эдийн засгийн бодит салбаруудад шинжлэх ухааны ололт амжилтыг хэрэгжүүлэх механизмыг бий болгосоноор үйлдвэрлэлийн салбарт амжилт гаргаж, улсын эдийн засгийн аюулгүй байдал өндөр үзүүлэлтэнд хүрсэн байна. 2012 он хүртэл шинжлэх ухааны хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг 25 дахин нэмэгдүүлж жилд 350 тэрбум тенгед хүргэх төрийн тэргүүний зорилт тавигдаад байна. Үүний тулд 2007-2012 он хүртлэх Шинжлэх ухааны хөгжлийн хөтөлбөр боловсруулж, Шинжлэх ухаан техникийн дээд комисс, Олон улсын экспортын зөвлөл, боловсрол, шинжлэх ухааны яамны оролцоотой Шинжлэх ухааны хороо, туршилтын болон зохион бүтээх төслүүдийг санхүүжүүлэн зохицуулах Шинжлэх ухааны сан, бүрэн тоноглогдсон 5 үндэсний нээлттэй лаборатори, инженерийн чиглэлийн их сургуулийн 15 лаборатори зэргийг байгуулах төлөвлөгөөтэй байна.

Өнөөгийн байдлаар улсын бүхий л мужид бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр батлагдсан. Жижиг хотуудын хөгжилд засгийн газраас 8431 сая тенге гаргасан байна. 2005 онд тосгонуудын 76,4 хувь нь цахилгаан утасны сүлжээнд холбогдсон байсан бол одоогийн байдлаар тосгонуудын 84,4 хувь нь цахилгаан утасны шугамд холбогдоод байна.

Юуны түрүүнд, Казахстанд хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдсэнийг хэлэх нь зүйтэй. Казахстан нь ТУХН-ийн орнуудыг нэг хүн амд ноогдох гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлж байна. Тусгаар тогтносноос хойш тус улс бараг 26 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруултыг татсан байна. ТУХН-ийн орнуудаас хамгийн эхэнд Казахстан улс хөрөнгө оруулалтын салбарт олон улсын рейтингтэй боллоо. Дэлхийн банк Казахстаныг хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүхий дэлхийн 20 орны жагсаалтанд багтаажээ. 1993 оноос хойш Казахстанд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 50 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт тогтвортой

хөгжсөөр байна. Дэлхийн 60 гаруй орон, тэдгээрийн дотор АНУ, Нидерланд, Их Британи, Итали, Хятад зэрэг орнууд Казахстаны эдийн засаг руу санхүүгийн нөөцөө чиглүүлээд байна.

Үүний зэрэгцээгээр дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. 2005 онд нийт 20 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн бол 2006 онд энэ үзүүлэлт 26 тэрбум ам.долларт хүржээ. Нийт 1 тэрбум ам.долларын хөрөнгө бүхий хөгжлийн банк, Казахстаны хөрөнгө оруулалтын сан, Үндэсний шинэчлэлийн сан зэрэг нь хөрөнгө оруулагчдын өргөн хүрээг хамарсан үйл ажиллагааг хангаж байна. 2006 оны 4-р сарын 1-ний байдлаар Казахстаны хөрөнгө оруулалтын санд нийт 8,9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын 351 санал ирсэн байна. Одоогийн байдлаар 170 гаруй тэрбум тенгегийн 34 төсөл батлагджээ. Уг сангийн болон бусад улсын хөгжлийн институтын үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын төслүүдийг сонгон шалгаруулах тогтолцоог бий болгох бодлогыг хэрэгжүүлэх болон Казахстаны эдийн засагт оруулах хөрөнгө оруулалтыг үр ашигтайгаар ашиглахад хяналт тавихад чиглэгдэнэ. Бас нэг давуу тал нь жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, нийт хүн амын бизнес эрхлэх идэвхийг дээшлүүлэх явдал юм. Одоогийн байдлаар 2005-2007 онын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна.

*Мэдээ бэлтгэсэн Г.Онон (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан)*